

Гепатит Д вирус

Гепатит Б вирусын эмнэлгийн тусламж
үйлчилгээ үзүүлэгчдэд зориулсан мэдээлэл

Гепатит Д вирус гэж юу вэ?

Гепатит Д вирус нь гепатит Д вирус (ГДВ)-ээр үүсгэгддэг халдварт өвчин бөгөөд вируст гепатитын бусад хэлбэрүүдээс элгийг хамгийн хүндээр гэмтээдэг элэгний халдвар юм. Зөвхөн гепатит В вирус тэй эсвэл халдвар авах эрсдэлтэй хүмүүст ГДВ халдварлах боломжтой бөгөөд ГБВ-тэй 20 өвчтөн тутмын 1 нь ГДВ-ын хавсарсан халдвартай байдаг.

Би яагаад ГБВ-тэй өвчтөнүүдээ ГДВ-ын шинжилгээнд хамруулах ёстой вэ?

Зөвхөн ГБВ-ын халдвартай өвчтөнүүдтэй харьцуулахад ГДВ-ын халдвар нь элэгний хатуурал болон элэгний хорт хавдар үүсэх явцыг илүү хурдасгадаг. ГБВ/ГДВ өвчтөнүүдэд хавсарсан халдвараа эмчлэхэд эмчилгээний өөр зөвлөмжүүд шаардагдлагатай болно.

Ямар хүмүүсийг шинжилгээнд хамруулах вэ?

- Африк, Зүүн Европ, Ойрхи Дорнод, Монгол, Энэтхэг, Пакистан, Төв Ази эсвэл Амазоны мөрний сав газраас гаралтай өвчтөнүүд
- ГБВ-ын эмчилгээнд хамрагдсан ч эмчилгээ үр дүнгүй эсвэл элэгний үйл ажиллагааны үзүүлэлтүүд хэвийн бус байгаа өвчтөнүүд
- Элэгний хатууралтай өвчтөнүүд



Өвчтөнүүдээ хэрхэн шинжилгээнд хамруулах вэ?

ГБВ/ГДВ хавсарсан халдварыг оношлох эхний алхам бол ГДВ-ын эсрэг бие илрүүлэх шинжилгээ юм. Хэрэв шинжилгээний хариу эерэг гарвал ГДВ-ын рибонуклеины хүчлийг тодорхойлох шинжилгээ хийж оношийг баталгаажуулна. Шинжилгээний талаарх дэлгэрэнгүй мэдээллийг:

[Centers for Disease Control and Prevention \(CDC\)](#), [ARUP Laboratories](#), [Quest Diagnostics](#).

ГБВ/ГДВ хавсарсан өвчтөнүүдийг хэрхэн хянах вэ?

Өвчтөнд пег-интерферон альфа эмийг бичиж өгдөг (саяхныг хүртэл ГДВ-ыг дарангуйлах цорын ганц эмчилгээ байсан). 2020 оны 7-р сард Европын эмийн агентлаг ГДВ-ын Гепклюдекс эмийг зөвшөөрсөн бөгөөд 2023 онд дэлхийн олон оронд худалдаална гэдэгт найдаж байна. Бусад төрлийн эмүүд ч судалгааны шатандаа явж байгаа. Одоо хамруулж байгаа эмнэлзүйн туршилтуудыг та эндээс харах боломжтой.